

**Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө
Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар
2022 оны жилийн эцэс**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ								
1		1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны	2022 он	АТГ-аас бэлтгэсэн мэдээллийн төрөл, тоо: Мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал а. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан мэдээллийн төрөл, тоо: б. Албан ёсны цахим хуудсаар дамжуулсан мэдээллийн төрөл, тоо: в. Нийгмийн сүлжээгээр дамжуулсан мэдээллийн төрөл, тоо:	-		Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллынхаа цахим хуудас, фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэж ажиллахыг 2022.02 дугаар сард төрийн болон орон нутгийн өмчит 32 байгууллагад хүргэж ажилласан. Мөн "Авлигыг мэдээллэх утас 110", авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан "Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье" зэрэг постеруудыг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын цахим хуудас, фэйсбүүк хуудсаар иргэдэд хүргэсэн. 2022 онд 19 байгууллага албан ёсны цахим хуудсаараа 77 төрлийн мэдээллийг 15 байгууллага фэйсбүүк хуудсаараа 77 мэдээллийг тус тус олон нийтэд хүргэж ажилласан байна. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран "Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье" соён гэгээрүүлэх арга хэмжээг 2022.04.09-ний өдөр аймгийн 114 иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 150 сурагчдын дунд зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс авлигын эсрэг үйл ажиллагааны 6 төрлийн постер мэдээлэлийг хэлтсийн	100%

	самбарт байршуулах зэрэг бүхий болон хэлбэрээр олон нийтэд хүргэх		г. Сурталчилгааны самбарт байршуулсан мэдээллийн төрөл, тоо: д. Бусад хэлбэрээр дамжуулсан мэдээллийн төрөл, тоо:		фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд цацаж 143 хандалт, 8 төрлийн видео, шторк 1327 хандалт авсан байна. Хавсралт нийт : 9 Файл : 1 Зураг : 8	
2	1.2. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	2022 он	АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээний тоо: Зохион байгуулсан арга хэмжээний тоо а. Байгууллагын түвшинд: б. Салбарын хэмжээнд: в. Орон нутгийн хэмжээнд:	350.000 төгрөг	Авлигатай тэмцэх газраас санаачлан хэрэгжүүлсэн "Зөв зөвд шударга зөв аян"-тай холбоотойгоор Авлигатай тэмцэх газрын фэйж хуудас, АТГ-Олон нийтийн зөвлөлийн фэйсбүүк хуудсанд нэгдэхийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Хуульчийн про-боно" арга хэмжээний үед болон төрийн 4 байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан сургалтаар иргэд, албан хаагчдыг нэгдүүлж ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газартай хамтран "Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье" соён гэгээрүүлэх арга хэмжээг 2022.04.09-ний өдөр аймгийн 114 иргэн сургалт, 200 иргэнд мэдээлэл хүргэж, ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 150 сурагчдын дунд сургалт зохион байгуулсан. 2022.09.24-ны өдөр зохион байгуулагдсан Баянтал сумын малчдын чуулганд "Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье" соён гэгээрүүлэх аяныг сурталчилж ажилласан. Нийт 43 малчин хамрагдсан. Мөн "Авлигатай тэмцэх газар", "Авлигын эсрэг олон нийтийн зөвлөл" гэсэн зөөврийн зурагт самбарыг хийж сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. "Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье" мэдээллийг иргэдэд хүргэх ажлын хүрээнд Сүмбэр сумын 3 дугаар баг Найрамдал хотхоны төв зам дагуу Онцгой байдлын газрын хашаанд Авлигыг мэдээлэх	100%

						утас 110, Таны эрх таны оролцоо Авлигад үгүй гэж хэлье, Зөв зөв шударга зөв яаныг сурталчилсан зургийг зуруулсан. Хавсралт нийт : 7 Файл : 1 Зураг : 6	
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах	2022 он	“Шударга ёс, хөгжил дэвшилд 110” самбарт байршуулсан мэдээллийн төрөл, тоо:	-	Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/255 дугаар албан бичгээр авлигын эсрэг үйл ажиллагааны Шударга ёс, хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбар байршуулж ажиллах чиглэлийг өгсөн. Чиглэлийн дагуу байгууллагууд мэдээллийн самбартаа авлигын эсрэг, төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, зурагт хуудас, гэх мэт мэдээллүүдийг байршуулсанг хагас бүтэн жилийн хяналт, шинжилгээ үнэлгээг хийхэд танилцаж ажилласан. 11 байгууллага давхардсан тоогоор 89 мэдээллийг байршуулсан байна. Хавсралт нийт : 8 Файл : 1 Зураг : 7	100%	
ХОЁР. АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ							
4	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлэх	2022 он	Сургалтын хөтөлбөрийн тоо: Хамрагдах ТАХ-ийн тоо:	-	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар хугацаанд нь хүргүүлсэн. Сургалтын хөтөлбөрийн дагуу төрийн албанд шинээр орсон 16, хэвлэл мэдээллийн 6, Мэргэжлийн хяналтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Боловсролын байгууллагын 46, эрх бүхий албан тушаалтан 31 тус тус хамрагдсан байна. Хавсралт нийт : 5 Файл : 1 Зураг : 4	100%	
5	2.2. АТГ-аас зохион байгуулдаг	2022 он	Анхан шатны сургалтын хөтөлбөрийн тоо:	-	Авлигатай тэмцэх газраас 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр цахимаар зохион байгуулагдсан анхан шатны	100%	

		авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулах		Хамрагдах ТАХ-ийн тоо:			сургалтад 16 албан хаагч хамрагдсан.	
6		2.3. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулах	2022 он	Давтан сургалтын хөтөлбөрийн тоо: Хамрагдах ТАХ-ийн тоо:	-		Сургалтын хөтөлбөрийн дагуу төрийн албан хаагчийн давтан сургалтад Мэргэжлийн хяналтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Боловсролын байгууллагын 46, эрх бүхий албан тушаалтан 31 тус тус хамрагдсан байна.	100%
7		2.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх	2022 он	Зохион байгуулсан арга хэмжээний тоо: Хамрагдах хүүхэд залуус, иргэдийн тоо:	-		Авлигатай тэмцэх газартай хамтран “Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” соён гэгээрүүлэх арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж 114 иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 150 сурагчийг хамруулсан. Мөн Авлигын эсрэг хууль, Авлига, албан тушаалын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн болон нутгийн захиргааны 10 байгууллагын 253 албан хаагчийг хамруулсан. “Хуульчийн про-боно” арга хэмжээний хүрээнд “Таны эрх-таны оролцоо, Авлигад үгүй гэж хэлье” уриалгыг Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 30 сурагч, 150 иргэнд хүргэсэн. “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ”-ний хүрээнд “АТГ-ын Олон нийтийн төв”, “Шударга ёс, хөгжил дэвшил-Авлигатай тэмцэх газар” стенийг бэлтгэж сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. Төмөр замын өртөө, Балдан засаг худалдааны төв, Хаан банк, Төрийн банк, нэгдсэн эмнэлэг зэрэг 12 байгууллагын хүлээлгийн танхимд урьдчилан сэргийлэх мэдээлэл авах 110 дугаар	100%

							утасны дугаар бүхий зурагт хуудас байршуулсан. Хавсралт : 1 файл	
ГУРАВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ								
8		3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	2022 он	Зөвлөмжийн тоо: Зөвлөмжид тусгагдсан арга хэмжээний тоо: Хэрэгжилтийн хувь:		-	Авлигатай тэмцэх газрын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн "Төрийн захиргааны албаны ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргуулах тухай" 02/8357 дугаар албан бичгийн дагуу удирдах албан тушаалтан болон хүний нөөцийн мэргэжилтэн, ангилал зэрэглэл нь өөрчлөгдсөн албан тушаалтнуудад мэдээллийг өгч ажилласан. Мэдээллийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн 3 албан хаагч нэмэгдэж ХАСХОМ гаргасан.	100%
9		3.2. Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2022 он	Мөрдөгчийн мэдэгдлийн тоо: Мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээний тоо: Хэрэгжилтийн хувь:		-	Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар мэдэгдлийн дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. МУ-ын ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолыг Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дугаар тогтоолоор "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталж, хэрэгжүүлж эхэлсэн. Энэ журмын дагуу 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр сумын ИТХурал хуралдаж СИТХ-ын 16 дугаар тогтоолоор "Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл"-ийг шинэчлэн байгуулсан. Хяналтын зөвлөлийн дарга : Х.Мөнхбаатар / СИТХ-ын АН-ын бүлгийн ахлагч / Нарийн бичиг : С.Оюунтүлхүүр Сумын ЗДТГ-ын ХЖДҮҮХоршоо хариуцсан мэргэжилтэн Гишүүн: Г.Батсүх /Аймгийн ХХААГ-ын ЖДҮйлдвэр хариуцсан мэргэжилтэн / Гишүүн :	70%

						<p>Э.Буянтогтох / Баянтал сумын ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн / Гишүүн: Цэцэгээ / Говьсүмбэр аймаг дахь Худалдаа, Аж үйлдвэрийн Танхимын салбарын дарга / Журмын дагуу 07 дугаар сард Хоршоо хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн эргэн төвлөрүүлэлт, зарцуулалт, ашиглалтад хяналт тавин ажиллаж хариуцсан мэргэжилтэнд зөвлөгөө, үүрэг даалгавар өгөн ажилласан. Одоо 12 дугаар сард багтан дахин 1 удаагийн хяналт хийгдэнэ. 2011-2015 оны СХСангийн зээлдэгчдээс иргэн С.Оюунчимэг “Оюут-Боржигон” ХХКомпанийг байгуулж өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар 2011-2015 онд сум хөгжүүлэх сангаас зээл аваад төлөөгүй нийт 8 зээлдэгчийн 40,792,036.00 / дөчин сая долоон зуун ерэн хоёр мянга гучин зургаа / төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс: Иргэн Б.Мөнхтамирын – 2,126,625.00 / хоёр сая нэг зуун хорин зургаан мянгазургаан зуун хорин тав/ төгрөг АТГ-ын дансанд төвлөрсөн Иргэн Б.Даариймаагийн 2,851,400.00 / хоёр сая найман зуун тавин нэгэн мянга дөрвөн зуу/ төгрөгийн өрийн үлдэгдэлтэй Иргэн Ч.Энхболд, Ш.Шинэбаяр, Ц.Батсайхан</p>	
10	3.3. Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2022 он	Албан бичгийн тоо: Албан бичигт тусгагдсан арга хэмжээний тоо: Хэрэгжилтийн хувь:	-	<p>Авлигатай тэмцэх газрын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 05/15592 дугаар албан бичгийн дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг дарга Т.Бат-Эрдэнэ нь 2022.10.07-ны өдөр "Чойр хаялга ёндоо" хоршоотой "Орон нутгийн такси үйлчилгээний гэрээ" байгуулах шийдвэр гаргахдаа Монгол Улсын такси үйлчилгээний MNS 5122:2013 стандартын 6 дугаар зүйл "Таксинд тавигдах шаардлага"-ын 6.1-д заасан "Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS4598:2011 стандарт болон дараах шаардлагыг хангасан, зүүн гар талдаа жолооны хүрдтэй</p>	100%	

						суудлын авто машин байна" гэх шаардлагыг хангаагүй хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, баталсан зөрчлийг арилгуулахыг даалгасан. Үүний дагуу Сүмбэр сумын Засаг дарга Т.Бат-Эрдэнэд зөрчлийг арилгуулах тухай мэдэгдэж, гэрээг цуцалсан байна.	
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ							
11	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах	2022 он	Хандсан байгууллага, иргэдийн тоо: Гаргасан саналын тоо: Дэмжсэн байгууллага, иргэдийн тоо: Дэмжсэн саналын тоо:		500.000 төгрөг	Монголын өмгөөлөгчдийн холбооны Говьсүмбэр аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран 2022.11.27-ны өдөр аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад "Хууль нь ёс суртахуунаас илүү хүнд нөлөөлдөг, Хүнд байгалийн хуулиас илүү нийгмийн хууль үйлчилдэг, Хүний мөн чанарыг мөнгө устгадаг, Үнэн аз жаргал авч ирдэг" гэсэн шийдлүүдийн хүрээнд Карл Попперин мэтгэлцээнийг зохион байгуулсан. Мэтгэлцээнд 5 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагчдын баг 1-р байрыг эзлэв.	100%
12	4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	2022 он	Гэрээ, хэлэлцээрийн тоо: Тусгасан заалтын тоо:		-	Төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажиллах гэрээг аймгийн Засаг даргатай байгуулж байгаа. тус гэрээнд авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж эрхэлсэн албан тушаалаа хууль, журмын дагуу гүйцэтгэхийг үүрэг болгон ажилласан.	100%
ТАВ. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ							
13	5.1. Авлигын эрсдэл ба авлига	2022 он	Цахим хэлбэрт шилжүүлсэн төрийн		-	Цахим хөгжлийн яам, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газартай хамтран 2022 оны 4 дүгээр сард	100%

		<p>гарах нөхцөлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх / төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м /</p>		<p>үйлчилгээний тоо: Үйлчилгээний стандарт шинээр нэвтрүүлсэн, шинэчилсэн тоо: Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулсан тоо: (хууль, дүрэм, журам шинэчлэх замаар) Эрсдэлийг бүртгэдэг, үнэлдэг эсэх</p>		<p>Говьсүмбэр аймгийн 15 байгууллагын 61 үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д холбосон. Үүнээс аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нараас олгогддог 3 төрлийн 26 үйлчилгээг цахимд бүрэн шилжүүлсэн байна. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар иргэдийн санал хүсэлтийг аймгийн албан ёсны цахим хуудас www.govisumber.gov.mn цахим сайтаар болон 70543434 утас, 11-11 төвөөр хүлээн авч шийдвэрлэж байна. Хагас жилийн байдлаар 70543434 дугаар утсанд 5 өргөдөл, цахимаар 2 өргөдөл ирснийг ирснийг 100 хувь шийдвэрлэсэн. 11-11 төвөөр нийт 12 өргөдөл ирснийг 3 өргөдлийг шийдвэрлэж, 9 өргөдөл шийдвэрлэх шатанд байна. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд Шивээговь, Сүмбэр сум нэвтрүүлээд байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2016, MNS ISO 18091:2020” стандартыг нэвтрүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулж Менежмент ба ур чадварын хүрээлэн ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж байна.</p>	
ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ							
14		<p>6.1. Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т</p>	2022 он	<p>а. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 – 6.1.6 заасан мэдээллүүдийг тогтоосон хугацаанд иж бүрэн тайлагнасан эсэх б. Шилэн дансны тухай хуулийн 6.4.1 – 6.4.9 заасан</p>	-	<p>Санхүүгийн хяналт, аудитын алба сар бүрийн 20-25-ны өдрийн хооронд шилэнд дансанд мэдээлэл оруулах нийт 75 байгууллагын мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 95.1 хувь, тайлан илгээлтийн хувь 100 хувь байна. Мөн 32 байгууллагад шилэн дансны мэдээ оруулалтад гүйцэтгэлийн аудит хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.</p>	100%

	заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах		мэдээллүүдийг 7 хоногийн дотор иж бүрэн тайлагнасан эсэх в. Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан мэдээллүүдийг тогтоосон хугацаанд иж бүрэн тайлагнасан эсэх				
Биелэлтийн хувь							97.8